Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	19,966.9	25,861.0	5,894.1	9.0
Эм боох материал	3,385.7	13,747.1	10,361.5	4.8
Дуусаагүй үйлдвэрлэл	40,220.6	36,185.0	(4,035.6)	12.6
Бичиг хэргийн материал	6,753.8	7,496.7	742.9	2.6
Аж ахуйн материал	114,139.2	142,192.1	28,052.9	49.4
Түлш, шатах тослох материал	399.9	1,200.0	800.1	0.4
Хүнсний материал	440.5	1,254.3	813.8	0.4
Бусад хангамжийн материал	-	17,181.3	17,181.3	6.0
Мал амьтад	425.8	-	(425.8)	0.0
Нөөцийн бараа	21,285.0	42,455.0	21,170.0	14.8
Дүн	207,017.4	287,572.6	80,555.2	100.00

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 80555.2 мянган төгрөг буюу 38.9 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн мөн аж ахуйн материалын сургуулийн камержуулалт, дотуур байрны 00-ын засвар, нөөцийн материал дансанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан өвс тэжээлийн үлдэгдлийг тайлагнасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Дуусаагүй үйлдвэрлэлд дансанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй наадмын талбайн засвар, цаг уурын станцын хашааны ажилд тайлант онд олгосон 36185.0 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2,476.9	3,332.6	855.7	1.16
Засаг даргын Тамгын газар	19,281.0	27,322.7	8,041.7	9.50
Сургууль	40,934.1	56,006.6	15,072.4	19.48
Цэцэрлэг	10,080.5	19,725.6	9,645.1	6.86

Эрүүл мэндийн төв	57,856.0	82,677.8	24,821.8	28.75
Соёлын төв	14,883.2	19,867.2	4,984.0	6.91
Орон нутгийн хөгжлийн сан	61,505.6	78,640.0	17,134.4	27.35
НИЙТ ДҮН	207,017.4	287,572.6	80,555.2	100.00

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 318716.7 мянган төгрөгийн бараа материалын 285730.1 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 11177.7 төгрөгийн материал хандиваар, 6296.1 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 15513.0 мянган төгрөгийн материал дотоод шилжүүлэг болоод бусад хэлбэрээр авсан байна.

Хандиваар авсан 11177.7 мянган төгрөгийн материалын Засаг даргын Тамгын газар 1247.6 мянга, Эрүүл мэндийн төв 8970.1 мянга, цэцэрлэг 960.0 мянган төгрөгийн Ковид-19 цар тахалтай холбоотой халдвар, хамгаалал, эм эмнэлгийн хэрэгсэл иргэн аж ахуйн нэгжээс хандиваар нийлүүлснийг бүртгэсэн байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	318,716.7	Хасагдсан	238,161.6
Худалдан авсан	285,730.1	Худалдсан, зарцуулсан	188,275.0
Хандиваар	11,177.7	Шилжүүлсэн	46,516.7
Шилжүүлэн авсан	6,296.1	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0.0
Бусад	15,513.0	Бусад	3,369.9

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6099664.1 мянга, эцсийн үлдэгдэл 6887293.0 мянган төгрөг болж, 787628.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	5,965,845.9	6,754,649.8	788,803.9	98.1
Барилга байгууламж, орон сууц	4,718,108.4	5,408,458.3	690,349.8	78.5
Тээврийн хэрэгсэл	225,820.7	265,280.7	39,460.0	3.9
Машин тоног төхөөрөмж	544,370.1	571,997.6	27,627.5	8.3
Тавилга эд хогшил	275,218.9	293,797.4	18,578.6	4.3
Зам гүүрний байгууламж	746.4	746.4	-	0.0
Түүх соёлын дурсгалт зүйл	1,306.7	1,306.7	-	0.0
Номын фонд	46,919.6	50,057.6	3,138.0	0.7
Бусад үндсэн хөрөнгө	153,355.2	163,005.2	9,650.0	2.4
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	133,818.2	132,643.2	(1,175.0)	1.93
Программ хангамж	10,392.2	9,217.2	(1,175.0)	0.1
Бусад биет бус хөрөнгө	123,426.0	123,426.0	-	1.8
НИЙТ ДҮН	6,099,664.1	6,887,293.0	787,628.9	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 787628.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, автомашиныг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж соёлын төвийн 142746.4 мянган төгрөгийн барилгыг акталж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 51 дүгээр тогтоолоор 30836.4 мянган төгрөгийн автомашиныг сумын Эрүүл мэндийн төвийн балансаас сургуулийн балансад шилжүүлж бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	11,414.0	16,849.0	5,435.0	0.2
Засаг даргын Тамгын газар	1,757,748.1	1,804,035.2	46,287.2	26.2
Сургууль	1,688,869.9	1,749,304.6	60,434.7	25.4
Цэцэрлэг	764,590.3	785,937.5	21,347.1	11.4

Эрүүл мэндийн төв	621,473.6	1,367,902.6	746,429.0	19.9
Соёлын төв	1,255,568.2	1,163,264.1	(92,304.1)	16.9
НИЙТ ДҮН	6,099,664.1	6,887,293.0	787,628.9	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 781551.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан ба эрүүл мэндийн төвд 728023.8 мянган төгрөгийн өргөтгөлийн барилга, Эрүүл мэндийн яамнаас нийлүүлсэн 37900,0 мянган төгрөгийн фургон машиныг тус тус шилжүүлж авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	984,186.7	Хасагдсан	196,557.8
Худалдан авсан	61,326.4	Худалдсан	0.0
Хандиваар	0.0	Акталсан	143,921.4
Шилжүүлэн авсан	781,551.9	Шилжүүлсэн	52,636.4
Бусад	141,308.3	Бусад	0.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4211.8 мянга, эцсийн үлдэгдэл 9480.3 мянган төгрөг болж 5268.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	4,211.8	9,480.3	5,268.6	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	194.0	433.4	239.4	4.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,927.8	7,303.9	3,376.1	77.0
Байгууллагад төлөх өглөг	-	1,743.0	1,743.0	18.4
Хувь хүмүүст төлөх өглөг	90.0	-	(90.0)	-
Дүн	4,211.8	9,480.3	5,268.6	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 433.4 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 7303.9 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, байгууллагад төлөх, 1743.0 мянган төгрөгийн бусад өглөг байгаа ба Эрүүл мэндийн төв дээр эм, эмнэлгийн хэрэгслийн 7303.9 мянган төгрөгийн өглөг, ажилчдын цалингаас хамтын сан, үйлдвэрчний эвлэлийн тооцоонд 340.3 мянган төгрөгийг дутуу суутгаж өглөгөөр бүртгэсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Сургууль	20.0	-	(20.0)	-
Цэцэрлэг	0.1	93.0	92.9	1.0
Эрүүл мэндийн төв	4,191.7	9,387.3	5,195.6	99.0
НИЙТ ДҮН	4,211.8	9,480.3	5,268.6	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5586668.9 мянга, эцсийн үлдэгдэл 6274862.3 мянган төгрөг болж, 688193.4 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,309,675.6	2,309,675.6	-	36.8
Өмч: - төрийн	2,309,675.6	2,309,675.6	-	36.8
Хуримтлагдсан үр дүн	711,930.0	1,440,123.4	728,193.4	23.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,565,063.3	2,525,063.3	(40,000.0)	40.2
Дүн	5,586,668.9	6,274,862.3	688,193.4	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6274862.3 мянган төгрөг болж 688193.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 728193.4 мянган төгрөгийн өсөлт, 40000.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2525063.3 мянган төгрөг болж 40000.0 мянган төгрөгөөр буурсан Соёлын төвийн хөрөнгөд бүртгэлтэй 142746.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий барилгыг акталж данснаас хассантай холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.19-ний өдрийн хуралдаанаар 15/11 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 143600.0 мянга, хүү торгуулийн орлогыг 10000.0 мянга, нийт 153600.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.10.07-ны өдрийн 15/18 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 66000.0 мянган төгрөгөөр хасаж тодотгон татварын орлогыг 72600.0 мянга, хүү торгуулийн орлогыг 15000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	72,600.0	74,150.3	1,550.3	102.1
1.1.ИОТХ	7,000.0	28,768.8	21,768.8	411.0
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	39,000.0	36,159.5	(2,840.5)	92.7
1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	-	2,780.0	2,780.0	-
1.4.Бууны татвар	1,200.0	1,050.4	(149.6)	87.5
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	10,700.0	1,055.3	(9,644.7)	9.9
1.6. Газрын төлбөр	5,400.0	656.1	(4,743.9)	12.1
1.7.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	6,000.0	2,869.3	(3,130.7)	47.8
1.8. ТТАМАТөлбөр	300.0	350.0	50.0	116.7
1.9. Нохойны татвар	3,000.0	461.0	(2,539.0)	15.4
2.Татварын бус орлого	15,000.0	6,785.8	(8,214.2)	45.2
2.1.Хүү торгуулийн орлого	15,000.0	6,785.8	(8,214.2)	45.2
Нийт дүн	87,600.0	80,936.2	(6,663.8)	92.4

Сумын төсөвт төвлөрөх иргэний орлого тодорхойлох хуудсаар хураах орлогын татвар, үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс бусад орлогын нэр төрөл дээрээ биелээгүйгээс татварын орлогыг 1550.3 мянган төгрөгөөр давсан, харин хүү торгуулийн орлого 8214.2 мянган төгрөгөөр тасарч, нийт 6663.8 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Сумын ИТХ-ын 2019.12.19-ны өдрийн хуралдаанаар 15/11 дугаар тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогыг нийт 1000.0 мянга, Соёлын төвийн орлогыг 2595.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр Засаг даргын Тамгын газар 175.0 мянга, Соёлын төв 1260.0 мянга нийт 1435.0 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 177769.9 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 54591.4 мянган төгрөгийн орлогыг оруулсан бол ОНХС-д өвс

тэжээл, малжуулахын эргэн төлөлтийн орлогоор 7027.0 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2474409.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2276074.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2134574.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 141503.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсөв батлах тухай 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолд зааснаар Баацагаан сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 5100.0 мянга, аймгийн төсөвт 114900.0 мянга, нийт 120000.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 124005.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №14. Улс, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	5100.0	6006.7	906.7	117.8
1. ААНБ-ын орлогын татвар	2100.0	2731.1	631.1	130.1
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1800.0	2015.4	215.4	112.0
3. Агаарын бохирдол /авто/	1200.0	1260.2	60.2	105.0
В. Аймгийн төсөв /712/	114900.0	117999.2	3099.2	102.7
1. ЦТХА орлого /Суутган -1/	95000.0	101803.6	6803.6	107.2
2. АТӨЯХ-ийн татвар	9500.0	12681.0	3181.0	133.5
3. ҮХЭХ-ийн татвар	2300.0	2671.5	371.5	116.2
4. Газрын төлбөр	8100.0	843.1	-7256.9	10.4
Нийт дүн	120000.0	124005.9	4005.9	103.3

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.19-ний өдрийн 15/11 дугаар тогтоолоор нийт 2581762.9 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	116,998.1	117,643.0	644.9
Засаг даргын Тамгын газар	454,190.9	394,443.2	(59,747.7)
Сургууль	827,822.3	858,650.9	30,828.6
Цэцэрлэг	334,190.2	316,829.8	(17,360.4)
Эрүүл мэндийн төв		477,201.1	477,201.1
Соёлын төв	146,340.5	106,008.5	(40,332.0)
Сум хөгжүүлэх сан		123,500.0	123,500.0
Орон нутгийн хөгжлийн сан		187,486.4	187,486.4
Нийт дүн	1,879,542.0	2,581,762.9	702,220.9

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.19-ний өдрийн 15/11 дугаар тогтоолоор анх баталсан 2581762.9 мянган төгрөгийг 2020.10.07-ны өдрийн 16/18 дугаар тогтоолоор 26734.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 14002.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 94621.1 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2474409.7 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1355473.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 33571.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 115590.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 665244.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 87600.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 130606.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 86323.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 23153.9 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 533.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	388,300.9	369,105.1	19,195.8	95.1
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	105,171.0	95,255.5	9,915.5	90.6
Ерөнхий боловсролын сургууль	820,933.1	798,352.6	22,580.5	97.2
Цэцэрлэг	273,928.5	248,468.2	25,460.3	90.7
Эрүүл мэндийн төв	477,201.1	471,116.8	6,084.3	98.7
Соёлын төв	106,708.5	105,220.0	1,488.5	98.6
Орон нутгийн хөгжлийн сан	178,666.6	141,502.9	37,163.7	79.2
Сум хөгжүүлэх сан	123,500.0	47,053.5	76,446.5	38.1
Нийт дүн	2,474,409.7	2,276,074.7	198,335.0	92.0

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2276074.7 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын урсгал зардлыг 9915.5 мянга, Засаг даргын Тамгын урсгал зардлыг 19195.8 мянга, цэцэрлэгийн урсгал зардлыг 25460.3 мянга, ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 22168.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг 74402.0 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг 37163.7 мянган төгрөгөөр дутуу олгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Баацагаан сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,474,409.7	2,276,074.7	198,335.0	92.0
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	105,171.0	95,255.5	9,915.5	90.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	86,701.7	77,585.1	9,116.6	89.5
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	18,469.3	17,670.4	798.9	95.7
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	388,300.9	369,105.1	19,195.8	95.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	266,419.3	257,846.3	8,573.0	96.8
80106 Баг, хорооны ҮАЗардал	88,794.2	80,560.7	8,233.5	90.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	6,427.3	6,427.3	-	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	23,500.0	23,076.7	423.3	98.2
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	3,160.1	1,194.0	1,966.1	37.8
70503 Орон нутгийн зорилгот хөрөнгө оруулалт	178,666.6	141,502.9	37,163.7	79.2
80904 Нийгмийн зориулалттай барилга	178,666.6	141,502.9	37,163.7	79.2
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	477,201.1	471,116.8	6,084.3	98.7
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	38,752.6	38,740.2	12.4	100.0
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	24,950.8	24,927.5	23.3	99.9

Баацагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч	413,497.7	407,449.0	6,048.7	98.5
71702 Соёл урлаг	106,708.5	105,220.0	1,488.5	98.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	104,424.7	102,936.2	1,488.5	98.6
80214 Уран бүтээл хийлгэх	1,983.8	1,983.8	-	100.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	300.0	300.0	-	100.0
71801 Сургуулийн өмнөх боловсрол	273,928.5	248,468.2	25,460.3	90.7
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	22,494.5	21,284.6	1,209.9	94.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	97.9	97.9	-	100.0
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	17,310.4	16,795.3	515.1	97.0
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	1,135.2	1,135.0	0.2	100.0
81833 Явуулын багшийн үйлчилгээ	3,213.8	2,934.8	279.0	91.3
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	199,997.4	179,331.5	20,665.9	89.7
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	29,679.3	26,889.0	2,790.3	90.6
71802 Ерөнхий боловсрол	812,141.9	789,973.4	22,168.5	97.3
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	121,770.3	115,819.5	5,950.8	95.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,372.6	1,372.6	-	100.0
81801 үдийн цай хөтөлбөр	12,977.1	9,670.1	3,307.0	74.5
81806 Дотуур байрны үйлчилгээ	82,197.3	74,135.4	8,061.9	90.2
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	443,222.0	440,478.8	2,743.2	99.4
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	150,602.6	148,497.1	2,105.5	98.6
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	8,791.2	8,379.2	412.0	95.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,791.2	8,379.2	412.0	95.3
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	123,500.0	47,053.5	76,446.5	38.1
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	123,500.0	47,053.5	76,446.5	38.1

Эх сурвалж: :Баацагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц хөрөнгө, засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс Иргэдийн төлөөлөгчийн хуралд 5000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 4 байгууллага 81484.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2 байгууллага 1155.0 мянга, нийт 87639.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	3,065.3	5,000.0	30,173.1	39,094.4	10,306.4	87,639.3
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000.0	-	-	-	5,000.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,610.3	-	30,173.1	39,094.4	9,606.4	81,484.3
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	455.0	-	-	-	700.0	1,155.0
НИЙТ ЗАРЛАГА	2,430.3		30,173.0	10,556.1	10,306.4	58,465.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,430.3	5,000.0	800.0	-	2,737.5	10,967.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	10,556.1	-	10,556.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	29,373.0	-	7,568.9	36,941.9
Төсөвт төвлөрүүлсэн	635.0		0.1	28,538.3		29,173.5

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	8	4	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл
2	Хагас жил	3	3	3	-	-
3	Улирал бүр	2	8	8	-	-
4	Сар бүр	5	60	60	-	-
5	Тухай бүр	6	72	72	-	-
НИЙТ		28	155	151	4	

Эх сурвалж. Баацагаан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 700.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 18 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/мянган төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	700.0	2	700.0			100.0
Нийт	2	700.0	2	700.0			100.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 санхүүгийн тайланд түүвэрт хамруулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 137950.0 мянган төгрөгийн 20 алдаа, зөрчил илэрснээс 37736.1 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31568.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 68670.9 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар

удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 заалт бүхий зөвлөмж өгч, 723.1 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулжээ.

Баацагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 228816.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулж ээлрүүлж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд Эрүүл мэндийн төвийн тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалыг нийт 12592.1 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;
 - Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг нийт 215672.9 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;
 - Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 459.2 мянга, эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн бараа ажил, ажил, үйлчилгээний бусад зардлыг 92.4 мянга нийт 551.6 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын мэдлэг ажлын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр Баацагаан сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллагын болон сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 **Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25



5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баацагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
			БНА-2021/13/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баацагаан сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
A	1	2	3	Албан тушаал	Овог нэр
1	Сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн байна.	228816.6	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	С.Энхтөр, А.Гэрэлмөнх
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	С.Энхтөр, А.Гэрэлмөнх
3	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	С.Энхтөр, А.Гэрэлмөнх
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүн		228816.6			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		138,698.1			
1	Тайлант оны жилийн эцэст 88 зээлдэгчийн 233515.6 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 44 зээлдэгчийн 32101.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн байна.	32,101.2	Төлбөрийн акт тогтоосон	Засаг дарга, нягтлан бодогч	С.Энхтөр, А.Номингэрэл
Цэцэрлэг		19,295.4			
2	Түлшний зардлаас байгууллагын багш, ажилтан нарт даргын 2020.12.18-ны өдрийн Б/26 тоот тушаалаар 1300,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.	1,300.0	Төлбөрийн акт тогтоосон	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Мөнхцэцэг, Г.Батдалай
3	Тус байгууллага нь 17995,4 мянган төгрөгийн хүнсний материалыг Буянт таван буурал хоршооноос худалдан авсан ба тухайн байгууллага нь татварын цахим сайтаас Е баримтыг хэвлэж өгөөгүй зөвхөн нэхэмжлэлээр гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн "28.5 Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй." гэсэн заалттай нийцэхгүй байна	17,995.4	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Мөнхцэцэг
4	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр байршуулах 3 төрлийн 3 мэдээлэл, нийт 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Мөнхцэцэг
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулж мөрдөж ажиллаж байгаа ба тухайн бичиг баримтыг сайжруулах шаардлагатай байна.	-	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Мөнхцэцэг
Сургууль		17,092.2			
6	Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2018 онд бүртгэсэн 1344.0 мянган төгрөгийн сандалд 268.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бодуулаагүй байна.	268.8	Санхүүгийн тайланд залруулсан	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
7	Тайлант онд нэр данс зөрүүтэй буцаж орж ирсэн цалингийн 454.3 мянган төгрөгийн гүйлгээг төрийн сангаас цэцэрлэгийн цалингийн зардалд хаасан байхад нягтлан бодогч тус буцсан гүйлгээний залруулгыг хийгээгүй цалингийн зардлаас давхар бичилт хийн авлагаар тусгасан байна.	454.3	Санхүүгийн тайланд залруулсан	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай

Баацагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
8	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчийг 2020 оны 09-11 сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахдаа төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл, анги даалт, кабинетын нэмэгдэл, зэрэг 996.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс нэмж олгосон.	996.5	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
9	Цалингийн зардлаас 2020 оны 10 дугаар багш ажилчдад нийт 4187.5 мянган төгрөгийн түлшний үнэ олгосон.	4,187.5	Төлбөрийн акт тогтоосон	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
10	Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаар 4 хөрөнгийн 547690.5 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл байхад санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 1007475.2 мянган төгрөг буюу 459784.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
11	Тус байгууллагын ажилтан Д.Саранбаатарыг 2020 оны 04 дүгээр сард ажлаас чөлөөлөхдөө 2 сарын цалинтай тэнцэх 871.5 мянган төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаас олгосон.	871.5	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
12	"Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй авлага үүсгэсэн.	9,950.0	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
13	Тайлант хугацаанд "Хонгор ойл" ХХК-аас худалдан авсан 363.6 мянган төгрөгийн шатахууны үнийг өглөгийн данс, бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардалд бичиж хаасан.	363.6	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
14	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас бүтэн жилээр болон тухай бүр оруулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүн гэсэн 73388.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Г.Насанбаяр, Г.Батдалай
Засаг даргын Тамгын газар		55,997.8			
15	Шилэн дансанд 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцруулж байршуулсан	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
16	Ой ангиас нийлүүлсэн 37148,0 мянган төгрөгийн өвс тэжээлээс 31568,0 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй, авлага өглөгийн тооцоо хийгээгүй байна.	31,568.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
17	Аймгийн ИТХТ-ийн 2008 оны 102 дугаар тогтоолоор тус сумын 2 цахилгаан моторыг "Баянхонгор Эрчим хүч ХХК-д шилжүүлэх шийдвэр гарсан боловч данснаас хасаагүй, нөөцөд бүртгэлтэй байгаа 9809,8 мянган төгрөгийн цахилгаан мотор эвдэрч ашиглагдахгүй байна.	24,429.8	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
Орон нутгийн хөгжлийн сан					
18	Шилэн дансны мэдээлэлд 193.9 мянган төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан байна	-	Зөвлөмж өгсөн	дарга, нягтлан бодогч	С.Энхтөр, А.Номингэрэл
Эрүүл мэндийн төв		14,211.5			
19	Нийгмийн даатгалын шимтгэлийг 147,4 мянган төгрөгөөр илүү төлж авлагаар бүртгээгүй байна	147.4	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Д.Болормаа, Н.Үүрцайх
20	Тус байгууллага нь 10 байгууллагад 14064,1 мянган төгрөг шилжүүлэхдээ анхан шатны баримтын бүртгэлгүй, гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн "28.5 Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	14,064.1	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Болормаа, Н.Үүрцайх
21	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байхгүй.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Болормаа, Н.Үүрцайх

Баацагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
22	Санхүүгийн тайланд тооцоо нийлж авлага өглөгөөр баталгаажуулаагүй холбогдох эзэн байгууллага нь тодорхойгүй эмийн 5340,2 мянган төгрөгийн авлага, 7303,9 мянган төгрөгийн өглөгийг холбогдох байгуулагд санал тавьж бүрэн шийдвэрлээгүй нь. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалттай нийцэхгүй байна	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Болормаа, Н.Үүрцайх

_____оОо_____